ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/128/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775

Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ....................................................3
Аудитын тайлан....................................................5
2.1. Оршил....................................................5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....................5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....................5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....................6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....................6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....................6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....................6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....................7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....................8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....................9
2.13. Шилэн дансны мэдээлэл ....................9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....................9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....................9
Менежментийн захидал ....................10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....................12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан....................13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .................... 14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.................... 15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....................16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....................17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....................18

**Аудитын гэрчилгээ**

БАЯНДУН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. Б.СЭРГЭЛЭНБААТАР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 1.1 2.1. Оршил

Дорнод аймгийн Баяндун сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Сэргэлэнбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно**.**

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-нээс 2020 оны 02 дугаар сарын 10–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 18 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар ”Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 1.2 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 1.3 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлогыг оновчтой хэрэгжүүлэн, үйлчлүүлэгчдэд ээлтэй тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог сайжруулна.

Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3: Хүний нөөцийн бодлогыг эрэлтэд нийцүүлэн тогтвортой хөгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

Зорилт 4: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, орон нутгийн хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлнэ.

Зорилт 5: Эрүүл мэндийн технологийн дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэн байгууллагын хөгжил, ээлтэй байдлыг бүрдүүлнэ.

Зорилт 6: Эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжтэй тогтвортой байдлыг хангаж, зайлшгүй шаардлагатай, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 1.4 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Axplorer программ хангамж ашигладаг байна.

Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 1.5 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 43 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 1.6 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 407,357.2 мянган төгрөгөөс тооцон 8,147.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,147.1 мянган төгрөгөөр тооцсон болно

## 1.7 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,560.8 мянган төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | - |
| Авлага | 0 | 0 | - |
| Урьдчилгаа | 0 | 0 | - |
| Бараа материал | 36,864.70 | 45,369.40 | 8,504.70 |
| Үндсэн хөрөнгө | 771,933.70 | 806,998.80 | 35,065.10 |
| Хуримтлагдсан элэгдэл | -92,621.50 | -114,630.50 | -22,009.00 |
| **Нийт хөрөнгө** | **716,176.90** | **737,737.70** | **21,560.80** |
| Өр төлбөр | | 0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 716,176.90 | 737,737.70 | 21,560.80 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **716,176.90** | **737,737.70** | **21,560.80** |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 8,504.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн эмийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 35,065.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалт болон хандивын хөрөнгө хүлээн авсан 49,895.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 8,330.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна

Үндсэн хөрөнгөөс 23,160.9 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 737,737.7 мянган төгрөг болж 21,560.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

## 1.8 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 367,953.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 320,465.6, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 31,134.1, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 16,354.2 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 363,325.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна. Зарцуулаагүй үлдэгдлийн 1,060.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлжээ.

**Нэмэлт төсөв:** Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас ахмадын болон хүүхдийн сувилалын зардалд 1,200.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас элэгний вирус илрүүлэг үзлэгийн санхүүжилт 1,540.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ээс сүрьеэгийн сорьц тээвэрлэх замын зардалд олгосон 215.4 мянган төгрөгийн санхүүжилтээр нэмэлт дансны орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: бараа үйлчилгээний бусад зардалд 1,200.0 мянгөн төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 1,540.0 мянган төгрөг, томилолтын зардалд 215.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 1.9 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 43 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 43 эрсдэл тодорхойлж нийт 43 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 79,939.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12,443.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 67,250.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 245.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 67,496.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 67,250.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Тайлант хугацаанд нийт 96,724.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаас 67,250.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт ”Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль

тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 1.10 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалыг жинхэнэ нэрээр нь буюу нэр төрлөөр нь бүртгэлд бүртгэж байх нь зүйтэй гэж үзлээ.

## 1.11 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баяндун сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 1.12 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 740.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг хугацаанд нь биелүүлсэн байна.

## 1.13 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Зөрчилгүй” дүгнэлт**

Баяндун сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Тээвэр шатахууны зарцуулалтыг жоолооны тооцооны хуудаснаас явсан зам км, зарцуулсан шатахууныг нормоор зарцуулсан эсэхийг тооцоолж шалгаж үзэхэд 245.8 мянган төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан байна.

*1.2. Эрсдэл:*

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалыг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

*2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн программ нь орон нутгийн өмчийн бүртгэлийн программын маягт гарахгүй байна.

*2.2. Эрсдэл:*

Бусад байгууллагуудад өгөх мэдээллийг боловсруулахгүй байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн программд шинэчлэлт хийлгэх.

*2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.14 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **36,864,774.7** | **45,369,353.7** |
| **БАРАА МАТЕРИАЛ** | 36,864,774.7 | 45,369,353.7 |
| **Түүхий эд материал** | 7,445,593.7 | 11,789,016.5 |
| Тусгай зориулалттай материал | 1,917,100.0 | 2,013,700.0 |
| Эм боох материал | 5,528,493.7 | 9,775,316.5 |
| **Хангамжийн материал** | 29,419,181.0 | 33,580,337.2 |
| Бичиг хэргийн материал | 1,145,650.0 | 853,330.0 |
| Аж ахуйн материал | 24,710,956.0 | 27,672,881.0 |
| Түлш, шатах тослох материал | 1,947,100.0 | 2,188,371.2 |
| Барилгын засварын материал | 202,500.0 | 202,500.0 |
| Хүнсний материал | 593,750.0 | 1,844,030.0 |
| Бусад хангамжийн материал | 819,225.0 | 819,225.0 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **679,312,147.1** | **692,368,376.5** |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 679,312,147.1 | 692,368,376.5 |
| **Биет хөрөнгө** | 651,590,147.1 | 664,646,376.5 |
| Барилга, байгууламж, орон сууц | 536,625,472.6 | 576,381,682.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (3,934,637.6) | (22,105,075.3) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 36,730,600.0 | 32,500,000.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (16,730,600.1) | (17,500,000.1) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 76,146,200.0 | 86,246,810.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (47,184,956.6) | (41,641,889.8) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,118,590.0 | 22,118,590.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (16,168,066.0) | (17,927,126.2) |
| Бусад үндсэн хөрөнгө | 57,190,824.0 | 61,629,774.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (8,203,279.2) | (15,056,388.6) |
| **Биет бус хөрөнгө** | 27,722,000.0 | 27,722,000.0 |
| Програм хангамж | 400,000.0 | 400,000.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (400,000.0) | (400,000.0) |
| Бусад биет бус хөрөнгө | 27,722,000.0 | 27,722,000.0 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **716,176,921.7** | **737,737,730.2** |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **716,176,921.7** | **737,737,730.2** |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 716,176,921.7 | 737,737,730.2 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 456,895,757.1 | 456,895,757.1 |
| Өмч: - төрийн | 456,895,757.1 | 456,895,757.1 |
| **Хуримтлагдсан үр дүн** | (19,057,631.7) | 2,503,176.7 |
| Өмнөх үеийн үр дүн | (19,057,631.7) | (19,057,631.7) |
| Тайлант үеийн үр дүн | | 21,560,808.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 278,338,796.3 | 278,338,796.3 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **716,176,921.7** | **737,737,730.2** |

## 3.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **300,017,115.7** | **428,918,036.9** |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | **15,421,073.2** | **62,637,086.9** |
| Нийтлэг татварын бус орлого | 15,421,073.2 | 62,637,086.9 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,421,073.2 | 62,637,086.9 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 15,421,073.2 | 62,637,086.9 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **284,596,042.5** | **366,280,950.0** |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 275,973,300.0 | 320,465,600.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 275,973,300.0 | 320,465,600.0 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,622,742.5 | 2,955,400.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,025,700.0 | 2,955,400.0 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 16,354,200.0 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 16,354,200.0 |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 26,505,750.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 26,505,750.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 310,891,677.2 | 401,107,228.6 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 310,891,677.2 | 401,107,228.6 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 309,831,390.5 | 401,107,228.6 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 162,301,707.0 | 210,562,929.0 |
| Үндсэн цалин | 127,803,936.0 | 157,946,344.0 |
| Нэмэгдэл | 23,542,619.0 | 30,788,453.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | - | 4,430,000.0 |
| Урамшуулал | 10,955,152.0 | 17,398,132.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,554,314.0 | 26,046,060.6 |
| Тэтгэврийн даатгал | 12,906,818.0 | 18,031,216.6 |
| Тэтгэмжийн даатгал | 1,701,088.0 | 2,121,629.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,361,084.0 | 1,697,301.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 325,939.0 | 381,447.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 3,259,385.0 | 3,814,467.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,619,873.0 | 15,273,736.0 |
| Гэрэл, цахилгаан | 5,360,029.0 | 5,433,231.0 |
| Түлш, халаалт | 10,259,844.0 | 9,640,505.0 |
| Цэвэр, бохир ус | - | 200,000.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 20,160,150.0 | 21,887,736.8 |
| Бичиг хэрэг | 2,260,690.0 | 2,648,420.0 |
| Тээвэр, шатахуун | 14,770,462.0 | 13,620,141.8 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,275,000.0 | 1,430,900.0 |
| Ном, хэвлэл | - | 83,000.0 |

| | | |
|---|---|---|
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,339,950.0 | 1,460,700.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 514,048.0 | 2,644,575.0 |
| Нормативт зардал | 25,699,981.7 | 40,644,782.2 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,277,219.7 | 34,263,355.1 |
| Хоол, хүнс | 7,422,762.0 | 6,381,427.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,194,020.0 | 3,239,100.0 |
| Урсгал засвар | 1,194,020.0 | 3,239,100.0 |
| Томилолт, зочны зардал | 1,686,000.0 | 4,576,600.0 |
| Дотоод албан томилолт | 1,686,000.0 | 4,576,600.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,659,725.0 | 28,190,953.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,696,825.0 | 26,767,831.3 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.0 | 180,000.0 |
| Даатгалын үйлчилгээ | 192,000.0 | 1,140,000.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 52,700.0 | 42,400.0 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.0 | 33,000.0 |
| Газрын төлбөр | 11,200.0 | 27,722.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,955,619.9 | 50,685,330.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 9,111,150.0 | 11,765,500.0 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,844,469.9 | 38,919,830.7 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (10,874,561.5) | 27,810,808.3 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,958,341.1 | 6,249,999.9 |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,958,341.1 | 6,249,999.9 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (1,958,341.1) | (6,249,999.9) |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(12,832,902.6)** | **21,560,808.4** |

## 3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **284,596,042.5** | **366,280,950.0** |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **284,596,042.5** | **366,280,950.0** |
| **Улсын төвлөрсөн төсвөөс** | 275,973,300.0 | 320,465,600.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 275,973,300.0 | 320,465,600.0 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,622,742.5 | 2,955,400.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,025,700.0 | 2,955,400.0 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,597,042.5 | - |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 16,354,200.0 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 16,354,200.0 |
| **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 26,505,750.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 26,505,750.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **284,596,042.5** | **366,280,950.0** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **284,596,042.5** | **366,280,950.0** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **283,535,755.9** | **366,280,950.0** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 162,301,707.0 | 210,562,929.0 |
| Үндсэн цалин | 127,803,936.0 | 157,946,344.0 |
| Нэмэгдэл | 23,542,619.0 | 30,788,453.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | - | 4,430,000.0 |
| Урамшуулал | 10,955,152.0 | 17,398,132.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,144,106.4 | 26,046,060.6 |
| Тэтгэврийн даатгал | 13,496,610.4 | 18,031,216.6 |
| Тэтгэмжийн даатгал | 1,701,088.0 | 2,121,629.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,361,084.0 | 1,697,301.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 325,939.0 | 381,447.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 3,259,385.0 | 3,814,467.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,977,693.0 | 16,354,200.0 |
| Гэрэл, цахилгаан | 5,360,029.0 | 5,433,231.0 |
| Түлш, халаалт | 9,617,664.0 | 10,720,969.0 |
| Цэвэр, бохир ус | - | 200,000.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 21,687,100.0 | 19,158,200.0 |
| Бичиг хэрэг | 2,694,350.0 | 2,400,000.0 |
| Тээвэр, шатахуун | 14,956,600.0 | 12,720,000.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,468,000.0 | 1,430,900.0 |
| Ном, хэвлэл | - | 83,000.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,427,150.0 | 1,440,000.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,141,000.0 | 1,084,300.0 |
| **Нормативт зардал** | 29,007,754.5 | 36,260,807.1 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,494,942.5 | 25,589,500.0 |
| Хоол, хүнс | 7,772,812.0 | 7,631,707.1 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,740,000.0 | 3,039,600.0 |

| | | |
|---|---|---|
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,822,320.0 | 13,365,700.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,550,000.0 | 10,126,600.0 |
| Урсгал засвар | 1,272,320.0 | 3,239,100.0 |
| **Томилолт, зочны зардал** | 1,686,000.0 | 4,576,600.0 |
| Дотоод албан томилолт | 1,686,000.0 | 4,576,600.0 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,659,725.0 | 28,190,953.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,696,825.0 | 26,767,831.3 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.0 | 180,000.0 |
| Даатгалын үйлчилгээ | 192,000.0 | 1,140,000.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 52,700.0 | 42,400.0 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.0 | 33,000.0 |
| Газрын төлбөр | 11,200.0 | 27,722.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,249,350.0 | 11,765,500.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,249,350.0 | 11,765,500.0 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.0** | **0.0** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.0** | **0.0** |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.0 | 0.0 |

## 4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 456,895,757.1 | 278,338,796.3 | (19,057,631.7) | 716,176,921.7 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **456,895,757.1** | **278,338,796.3** | **(19,057,631.7)** | **716,176,921.7** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | | - |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **456,895,757.1** | **278,338,796.3** | **(19,057,631.7)** | **716,176,921.7** |
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **456,895,757.1** | **278,338,796.3** | **(19,057,631.7)** | **716,176,921.7** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **456,895,757.1** | **278,338,796.3** | **(19,057,631.7)** | **716,176,921.7** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 21,560,808.4 | 21,560,808.4 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **456,895,757.1** | **278,338,796.3** | **2,503,176.7** | **737,737,730.2** |

## 4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 367,953,900.0 | 363,325,550.0 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 367,953,900.0 | 363,325,550.0 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 367,953,900.0 | 363,325,550.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 212,999,500.0 | 210,562,929.0 |
| Үндсэн цалин | 157,061,900.0 | 157,946,344.0 |
| Нэмэгдэл | 31,907,700.0 | 30,788,453.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 4,720,000.0 | 4,430,000.0 |
| Урамшуулал | 19,309,900.0 | 17,398,132.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,625,000.0 | 26,046,060.6 |
| Тэтгэврийн даатгал | 18,104,500.0 | 18,031,216.6 |
| Тэтгэмжийн даатгал | 2,130,500.0 | 2,121,629.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,703,600.0 | 1,697,301.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 426,200.0 | 381,447.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 4,260,200.0 | 3,814,467.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,354,200.0 | 16,354,200.0 |
| Гэрэл, цахилгаан | 5,414,700.0 | 5,433,231.0 |
| Түлш, халаалт | 10,739,500.0 | 10,720,969.0 |
| Цэвэр, бохир ус | 200,000.0 | 200,000.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 19,722,800.0 | 19,158,200.0 |
| Бичиг хэрэг | 2,400,000.0 | 2,400,000.0 |
| Тээвэр, шатахуун | 12,720,000.0 | 12,720,000.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,807,500.0 | 1,430,900.0 |
| Ном, хэвлэл | 208,000.0 | 83,000.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.0 | 1,440,000.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,147,300.0 | 1,084,300.0 |
| Нормативт зардал | 35,411,100.0 | 34,720,807.1 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,049,500.0 | 24,049,500.0 |
| Хоол, хүнс | 8,250,000.0 | 7,631,707.1 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,111,600.0 | 3,039,600.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 13,365,700.0 | 13,365,700.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 10,132,700.0 | 10,126,600.0 |
| Урсгал засвар | 3,233,000.0 | 3,239,100.0 |
| Томилолт, зочны зардал | 4,611,500.0 | 4,361,200.0 |
| Дотоод албан томилолт | 4,611,500.0 | 4,361,200.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,298,600.0 | 28,190,953.3 |

| | | |
|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,784,100.0 | 26,767,831.3 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.0 | 180,000.0 |
| Даатгалын үйлчилгээ | 1,140,000.0 | 1,140,000.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 52,700.0 | 42,400.0 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.0 | 33,000.0 |
| Газрын төлбөр | 77,800.0 | 27,722.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,565,500.0 | 10,565,500.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,565,500.0 | 10,565,500.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 367,953,900.0 | 363,325,550.0 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 320,465,600.0 | 320,465,600.0 |
| Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 320,465,600.0 | 320,465,600.0 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 16,354,200.0 | 16,354,200.0 |
| Орон нутгийн төсвөөс | 16,354,200.0 | 16,354,200.0 |
| НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 31,134,100.0 | 26,505,750.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,134,100.0 | 26,505,750.0 |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.0 | 1.0 |
| Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24.0 | 24.0 |
| Удирдах ажилтан | 1.0 | 1.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 15.0 | 15.0 |
| Үйлчлэх ажилтан | 4.0 | 4.0 |
| Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24.0** | **24.0** |
| Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16.0 | 16.0 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4.0 | 4.0 |
| Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 |